

	Нийтлэг мөрддөг хуулийн тоо: 11	6. Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл ахуйн тухай хууль
		<ol style="list-style-type: none"> 1. Төрийн албаны тухай хууль 2. Төсвийн тухай хууль 3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 4. Шүүх шинжилгээний тухай хууль 5. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль 6. Хувь хүний нууцын тухай хууль 7. Кибер аюулгүй байдлын тухай хууль 8. Мэргэжлийн хяналтын тухай хууль 9. Нийгмийн халамжийн тухай хууль 10. Статистикийн тухай хууль 11. Хөдөлмөрийн тухай хууль

Ерөнхий чиг үүрэг-1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх.

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх	1.Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох	ХЗДХЯ, ДЭМБ, ЭМЯ, СЭМҮТ
		2.Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цогц төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	ЭМЯ, СЭМҮТ, НЭМГ
		3.Гамшиг, нийтийг хамарсан өвчлөл, гэнэтийн аюул ослын асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн менежментийн чадавхыг бэхжүүлэх	ЭМЯ, СЭМҮТ
1.2	Эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлж нотолгоонд үндэслэн хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих	1.Сэтгэцийн зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгааг өрөгжүүлж, нотолгоонд тулгуурласан шинжлэх ухааныг хөгжүүлэх	ДЭМБ, ЭМЯ, ХЗДХЯ, СЭМҮТ

Ерөнхий чиг үүрэг-2: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй үзүүлж, хүний нөөцийг хөгжүүлэх.

№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
2.1	Сэтгэцийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх	1.Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай хүний нөөцийг үе шаттайгаар төлөвлөж тусламж үйлчилгээг бэхжүүлэх	ЭМХТ, СЭМҮТ ЭМЯ
2.2	Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх	1.Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг өрөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	ЭМЯ, СЭМҮТ, Дүүрэг аймгуудын СЭМ-ийн кабинет, тасаг
		2.Технологи инновацыг тэгш хүртээмжтэй ашиглах боломжийг бүрдүүлэн, сургаж хөгжүүлэх	
		3.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулж, эрсдлийг бууруулах	

Ерөнхий чиг үүрэг-3: Байгууллагын хөгжил, ил тод байдлыг хангах.			
№	Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
3.1	Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалт, ил тод байлыг хангах	1.Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх	ЭМЯ, СЭМҮТ
		2.Төвийн санхүүгийн төлөвлөтийг шинэчлэн, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх	

ГУРАВ. АЛСЫН ХАРАА, УРИА

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжингүй орны түвшинд хүргэж нийгмийн эрүүл мэндийн тэргүүлэх салбар болгоно.

УРИА: “СЭТГЭЦ ЭРҮҮЛ БОЛ БИЕ ЭРҮҮЛ”

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, жигд, тэгш, хүртээмжтэй үзүүлэн, анхан болон үндсэн мэргэжлийн тусламжийг мэргэжил арга зүйгээр хангаж эмчилгээ үйлчилгээнд технологийн шинэчлэлийг хийхэд оршино.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн орчны шинжилгээний үр дүнг дараах SWOT хүснэгтэд нэгтгэн давуу ба сул тал, боломж ба эрсдэлийг тодорхойлов.

Хүснэгт 2. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн орчны шинжилгээний үр дүн

Байгууллагын дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> Сэтгэцийн эрүүл мэндийн лавлагаа шатлалын тусламжуудыг мэргэжил арга зүйн хувьд удирддаг. Бүх аймаг дүүрэг бүрт сэтгэцийн болон донтолтын кабинет, мэргэжлийн эмч нар ажилладаг. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд АШУҮИС – н сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим нь байршдаг учир хамтын ажиллагаа сайтай. Сэтгэц судлалын чиглэлээр төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтыг авах хүсэлтэй их дээд сургуулиудын бааз төв юм. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь нийт 2284м² талбай бүхий 7 капитал барилга, 84000 м² бүхий өмчлөл газартай. Хөдөлмөрийн хэвийн бус нэмэгдлүүдтэй. /ажлын хорогдуулсан 6 цагийн хөдөлмөр эрхэлдэг, эмэгтэй нь 50 нас, эрэгтэй нь 55 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй 	<ul style="list-style-type: none"> СЭМҮТ нь өөрийн дэд бүтэцтэй дулааны системд холбогдоогүй учир аж ахуйн үр ашиггүй зардал ихтэй, агаарын бохирдол хөрсний бохирдол үүсгэх голомт болдог. Улс орон даяар өсвөр үе залуучууд сэтгэц нөлөөт эм бодис, мансууруулах бодист олноороо нэрвэгдэж гэмт хэрэгт холбогдох нь ихсэж байгаа тул дээрх эмгэгийг эмчлэх сүүлийн үеийн арга, аргачлал технологи нэвтрүүлэх, уг эмгэгийг албадан эмчлэх хууль зүйн үндэслэлийг шинэчлэх шаардлагатай байна. Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 50 гаруй хувь нь гэр оронгүй, харж хандах асрах хүнгүй өвчтөнүүд эзэлдгээс тасаг клиникийн орны эргэлт удааширч сүүлийн үед хэвтүүлэн эмчлэх өвчтөний тоо эрс өссөн байна. Үндэсний хөтөлбөр, сэтгэцийн эрүүл мэндийн хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт зохиох, УБ хот болон орон нутагт нийгэм хамт олонд